



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

НЭГ. Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 216 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-д дор дурьдсан агуулга бүхий заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дахь хэсгийн 3.5.4 дэх заалт:

“Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй байх”

2/ 5 дахь хэсгийн 5.3.8 дахь заалт:

“Туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого, гарсан зардал, ашгийн тооцоо, танилцуулга, нотлох баримт”

3/ 8 дахь хэсгийн 8.2 дахь заалт:

“Улсын төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газар улирал бүрийн дараа сарын 5-ны дотор Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлнэ”

4/ 3 дахь хэсгийн 3.3¹ дахь заалт:

“Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, тарифт орсон өөрчлөлттэй холбоотойгоор нэмэгдсэн үндсэн үйл ажиллагааны орлогыг давсан орлогод тооцохгүй”

ХОЁР. Журмын 5 дахь хэсгийн 5.2 дахь заалтын “хагас жил тутам” гэснийг “хагас жилийн гүйцэтгэл, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн” гэж, 6 дахь хэсгийн 6.1.1 дэх заалтын “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 3-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 3-ны дотор” гэж, уг

хэсгийн 6.1.2, 6.1.3, 6.1.4 дэх заалтуудын “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 6-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 6-ны дотор” гэж тус тус, уг хэсгийн 6.1.5 дахь хэсгийн “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 9-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 9-ны дотор” гэж, уг хэсгийн 6.1.6 дахь заалтын “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 12-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 12-ны дотор” гэж, уг хэсгийн 6.1.8 дахь заалтын “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 15-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 25-ны дотор” гэж, уг хэсгийн 6.1.9 дахь хэсгийн “сүүлийн хагас жилийн байдлаар 11 дүгээр сарын 15-ны дотор” гэснийг “жилийн эцсийн байдлаар 11 дүгээр сарын 25-ны дотор” гэж, журмын 4 дэх хэсгийн 4.4 дэх заалтын “Төсвийн зарлагын хэмнэлтийг “Зарлагын хэмнэлтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ” гэсэн зардлын зориулалтын ангиллаар төсвийн зарлагын сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан санхүүжүүлнэ. Хуваарьт өөрчлөлт оруулахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулах дүнг “Хэмнэлтээр төсвийн санхүүжилт бууруулах” гэсэн эх үүсвэрийн ангилалд тусгана” гэснийг “Төсвийн зарлагын хэмнэлтийг “Зарлагын хэмнэлтийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ” гэсэн зардлын зориулалтын ангиллаар төсвийн зарлагын сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан санхүүжүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

ГУРАВ. Журмын 7 дахь хэсгийн 7.6, 7.7 дахь заалтыг тус тус хассугай.

ДӨРӨВ. Журмын 6 дугаар зүйлийн 6.1.1-ээс 6.1.9-д заасан цаглабарыг 2018 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТАВ. Журмын нэмэлт, өөрчлөлт батлагдсан тухай зохих мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагчдад түгээх ажлыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т үүрэг болгосугай.



Ч.ХҮРЭЛБААТАР